



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: М.Энхжаргал

Утас:70432545 Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.08.21 № 2/17
танай _____-ны № _____-т

ХОВД СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Е.УАТХАН ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Ховд сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тус байгууллага худалдан авах ажиллааг зохион байгуулсан ч 8,864.0 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд худалдан авсан,
- Сургуулийн захирал нь мах нийлүүлэх гэрээ байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан бараа бүтээгдэхүүний нэгжийн үнийг баримтлаагүй гэрээ байгуулснаар 3,103.5 мянган төгрөгийн төсвийн үрэлгэн зардал гаргасан,
- Хүнсний материалаас түүвэрлэн хянахад хүнсний ногооны орлого бүртгэсэн боловч тулган баталгаажуулалтаар хэрчсэн гурил худалдан авч, анхан шатны баримтыг өөрчилж орлого авсан 2,420.0 мянган төгрөг,
- Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй 3,250.0 мянган төгрөг,
- Дотуур байр болон бага ангийн хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүнийг нормативаас илүү зарцуулсан 4,498.2 мянган төгрөг,
- Ажилчдад цалин хөлс илүү олгож, цалинг суутгаж аваагүй 2,113.5 мянган төгрөг,

- Өмнөх аудитаар өгөгдсөн 2 төлбөрийн актын 3,803.0 мянган төгрөгийн хэрэгжилтийг хангаагүй, өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй,
- Байгууллага нь үндсэн хөрөнгийн бүртгэлд ямар ч газар эзэмших эрх бүртгэгдээгүй,
- Хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгөд тавих хяналт сул,
- Дотуур байр болон үдийн хоолны хүүхдийн илчлэгийн нормыг тооцоогүй,

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ховд сумын Сургууль нь тайлант онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 330,815.9 мянган төгрөгийн дотуур байрны их засвар, тавилга, тоног төхөөрөмж, 6,480.1 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл хүлээн авч үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сургуулийн бүсийг утасгүй интернэтээр хангах, цахим анги байгуулах санхүүгийн түрээсийн гэрээг 110,268.7 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотойгоор өр төлбөр өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

 Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>215,635,758.87</u>	<u>298,549,050.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,837,633.87	158,945,799.68
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	110,837,633.87	158,945,799.68
3121	Төгрөг	110,837,633.87	158,945,799.68
31211	Төрийн сангийн харилцах	110,837,633.87	158,945,799.68
33	АВЛАГА	-	52,324,878.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	50,351,078.50
335	Бусад авлага	-	1,973,800.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,973,800.00
34	УРЬДЧИЛГАА	1,690,000.00	7,482,900.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	5,792,900.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,690,000.00	1,690,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,690,000.00	1,690,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	103,108,125.00	79,795,472.49
351	Түүхий эд материал	147,200.00	6,551,238.49
35110	Тусгай зориулалттай материал	-	6,551,238.49
35130	Эм боох материал	147,200.00	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	216,700.00	-
354	Хангамжийн материал	102,744,225.00	73,244,234.00
35420	Аж ахуйн материал	1,750,000.00	1,750,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,600.00	9,600.00
35450	Барилгын засварын материал	2,118,591.00	-
35460	Хүнсний материал	28,814,100.00	1,432,700.00
35470	Бусад хангамжийн материал	70,051,934.00	70,051,934.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,613,409,246.28</u>	<u>3,923,762,337.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,613,409,246.28	3,923,762,337.78
391	Газар	9,240,000.00	9,240,000.00
392	Биет хөрөнгө	3,558,871,819.30	3,869,224,910.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,373,650.00	3,575,136,650.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(164,066,922.20)	(197,552,404.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	246,289,734.00	445,289,184.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(145,532,845.53)	(170,734,021.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,399,108.86	337,215,640.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(125,935,349.75)	(162,474,582.51)
39217	Ном	42,344,443.92	42,344,443.92
393	Биет бус хөрөнгө	45,297,426.98	45,297,426.98
39301	Програм хангамж	1,075,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(765,573.02)	(765,573.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,988,000.00	44,988,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,829,045,005.15</u>	<u>4,222,311,388.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>122,703,526.70</u>

Ховд сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	122,703,526.70
413	Өглөг	-	122,703,526.70
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	11,529,113.35
4136	Бусад өглөг	-	111,174,413.35
41361	Байгууллагад төлөх өглөг	-	111,174,413.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,829,045,005.15	4,099,607,861.75
51	Засгийн газрын хувь оролцоо	3,829,045,005.15	4,099,607,861.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837,165,419.00	837,165,419.00
51101	Өмч: - төрийн	837,165,419.00	837,165,419.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,126,887,522.43	2,397,450,379.03
51210	Өмнөх үеийн үр дүн	2,126,887,522.43	2,126,887,522.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	270,562,856.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,992,063.72	864,992,063.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,829,045,005.15	4,222,311,388.45

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,019,035,121.25	3,111,147,320.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,794,934.72	286,673,620.59
120	Нийтлэг татварын бус орлого	14,794,934.72	286,673,620.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,794,934.72	283,128,764.69
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	17,778,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,794,934.72	265,350,364.69
120005	Түрээсийн орлого	-	2,544,855.90
120009	Бусад орлого	-	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,004,240,186.53	2,824,473,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,004,240,186.53	2,436,395,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	308,626,300.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,695,613,886.53	2,436,395,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	388,078,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	388,078,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,916,506,940.47	2,840,584,463.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,916,506,940.47	2,840,584,463.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,916,506,940.47	2,838,303,413.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,156,042,143.70	1,617,857,301.37
210101	Үндсэн цалин	1,109,750,095.50	1,617,857,301.37
210102	Нэмэгдэл	17,468,781.04	-
210104	Урамшуулал	28,823,267.16	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,839,130.98	418,005,186.47
210201	Тэтгэврийн даатгал	104,728,600.00	126,278,195.70
210202	Тэтгэмжийн даатгал	12,320,900.00	41,541,495.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,951,957.92	86,971,588.86

Ховд сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	4,081,350.00	21,961,537.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,756,323.06	141,252,369.59
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301,861,959.50	395,637,062.68
210301	Гэрэл, цахилгаан	9,785,524.34	13,965,949.33
210302	Түлш, халаалт	292,076,435.16	380,235,113.35
210303	Цэвэр, бохир ус	-	1,436,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,949,500.00	1,845,515.00
210401	Бичиг хэрэг	-	616,515.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,949,500.00	1,229,000.00
2105	Нормативт зардал	179,262,100.00	209,597,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	147,200.00
210502	Хоол, хүнс	179,262,100.00	209,449,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,871,500.00	4,368,591.00
210604	Урсгал засвар	3,871,500.00	4,368,591.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,811,100.00	5,075,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,566,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,811,100.00	6,641,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,869,506.29	185,917,196.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,987,833.33	76,232,406.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,363,549.96	14,458,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,518,123.00	95,225,890.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,281,050.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,281,050.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	102,528,180.78	270,562,856.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	102,528,180.78	270,562,856.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,004,240,186.53	2,843,252,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	18,778,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	18,778,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	17,778,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	17,778,400.00
120009	Бусад орлого	-	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,004,240,186.53	2,824,473,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,004,240,186.53	2,436,395,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	308,626,300.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,695,613,886.53	2,436,395,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	388,078,000.00

Ховд сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	388,078,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,890,314,952.66	2,795,143,934.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,890,314,952.66	2,795,143,934.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,838,290,352.66	2,746,054,523.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,016,144.74	1
210101	Үндсэн цалин	754,966,507.52	1,175,894,831.34
210102	Нэмэгдэл	356,174,818.89	593,698,572.38
210104	Урамшуулал	48,874,818.33	78,704,262.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,724,407.92	237,915,900.00
210201	Тэтгэврийн даатгал	104,728,600.00	161,782,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,320,900.00	19,033,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,951,957.92	9,385,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,081,350.00	9,516,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,641,600.00	38,197,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301,489,541.00	383,546,949.33
210301	Гэрэл, цахилгаан	10,180,541.00	13,965,949.33
210302	Түлш, халаалт	291,309,000.00	368,706,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	875,000.00
2105	Нормативт зардал	131,568,300.00	123,789,000.00
210502	Хоол, хүнс	131,568,300.00	123,789,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,136,759.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	7,136,759.00	2,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,770,900.00	47,567,357.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	16,462,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,770,900.00	31,105,157.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,584,300.00	102,687,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,976,000.00	88,034,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,608,300.00	14,653,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,024,600.00	49,089,410.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,024,600.00	46,808,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,024,600.00	46,808,360.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,281,050.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,281,050.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	113,925,233.87	48,108,165.81
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	113,925,233.87	48,108,165.81
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,837,633.87
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,837,633.87	158,945,799.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Ховд сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,126,887,522.43	3,829,045,005.15
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	270,562,856.60	270,562,856.60
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,397,450,379.03	4,099,607,861.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2954858933.87	2792862883.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2954858933.87	2792862883.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2900448133.87	2746054523.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1932405000.00	1848297666.34
210101	Үндсэн цалин	1330425900.00	1175894831.34
210102	Нэмэгдэл	551427700.00	593698572.38
210104	Урамшуулал	50551400.00	78704262.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241550533.87	237915900.00
210201	Тэтгэврийн даатгал	164254400.00	161782800.00
210202	Тэтгэмжийн даатгал	19324000.00	19033300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9662000.00	9385600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9662000.00	9516600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38648133.87	38197600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385828000.00	383546949.33
210301	Гэрэл, цахилгаан	15958600.00	13965949.33
210302	Түлш, халаалт	368706000.00	368706000.00
210303	Цэвэр, бохир ус	1163400.00	875000.00
2105	Нормативт зардал	185,245,000.00	123,789,000.00
210502	Хоол, хүнс	185,245,000.00	123,789,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,329,200.00	47,567,357.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,507,600.00	16,462,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,821,600.00	31,105,157.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,840,400.00	102,687,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,187,000.00	88,034,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,653,400.00	14,653,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,410,800.00	46,808,360.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	54,410,800.00	46,808,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,410,800.00	46,808,360.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,954,858,933.87	2,840,971,049.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,824,473,700.00	2,822,192,649.33
131001	Улсын төсвөөс санхүүжих	388,078,000.00	385,796,949.33
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,436,395,700.00	2,436,395,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	13,532,000.00	17,778,400.00
12009	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,015,600.00	1,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	110,837,633.87	110,837,633.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		158,945,799.68
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	69.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	69.00	69.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	42.00	42.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	21.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 748,658.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 603,299.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас хөрөнгө оруулалтаар ирсэн 25,190.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байсныг залруулсан,
- Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, орон нутгийн төсвөөс санхүүжих 387,285.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн байсныг санхүүжилтээс хасаж, өөрийн орлого болон орон нутгийн санхүүжилтээр,
- Сургалтын төлбөр болох 5,792.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч үйлчилгээ аваагүй байхад шууд зардалд бүртгэсэн байсныг урьдчилж төлсөн зардалд
- Цахим танхим болон интернэт орчинтой холбоотой 110,268.7 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүй байсныг байгууллагад төлөх өглөгт
- Дотуур байрны их засварт зарцуулсан 74,763.0 төгрөгийн хөрөнгийг капиталжуулаагүй байсныг,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Залруулагдаагүй 145,358.4 мянган төгрөгийн 6 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 145,358.4 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 9,861.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 11,967.6 мянган төгрөгийн албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн 3,250.0 мянган төгрөгийн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй, дотуур байр болон бага ангийн хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүнийг нормативаас илүү зарцуулсан 4,498.2 мянган төгрөг, бүгд 7,748.2 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдээгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдээгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг 11.1.6-т "хоолны норматив зардлыг өөр зориулалтаар ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.1.2 Ажилчдад 2,113.5 мянган төгрөгийг илүү олгож, цалинг суутгаж аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2. Албан шаардлага:

Хүүхдийн хоолны зарцуулалтыг хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд.

- Тус сургуулийн захирал нь мах нийлүүлэх гэрээ байгуулахдаа сумын ЗДТГ-аас зарласан дотуур байрны хоолны техникийн тодорхойлолтод заасан бараа бүтээгдэхүүний нэгжийн үнийг баримтлаагүй гэрээ байгуулсан (үхрийн махыг 1 кг-ыг 13000 төгрөгөөр худалдан авахаар техникийн тодорхойлолтод заасан байхад мах бэлтгэн нийлүүлэх гэрээнд үнийн мэдээллийн 95 хувиар тооцох гэж тусгасан) байна.
- Тендерийн үнээс зөрүүтэй худалдан авсан тоо хэмжээ болон худалдан авах ажиллагаанд шалгараагүй компанийн нийлүүлэлтийг хянахад 11,967.5 мянган төгрөгийн төсвийн үрэлгэн зардал гарсан,
- Сургуулийн дотуур байр болон үдийн хоолны хүүхдийн илчлэгийн нормыг тооцоогүй, ихэвчлэн бэлэн гурилан бүтээгдэхүүн өгдөг байдлыг зогсоож, шинээр үйлдвэрлэсэн, тэжээллэг хоол хүнс нийлүүлэх, жимс, ногоо, мах, сүү,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
ХОА-2025/118/НА-СТА-ТШЗ

- сүүн бүтээгдэхүүн зэрэг төрөл бүрийн хүнсийг хоолны цэсэд оруулж, махны өндөр үнийг бууруулж, чанартай мах нийлүүлэн, хоол зүйчийг ажиллуулаагүй.
- Байгууллагын хүнсний материалаас түүвэрлэн хянахад хүнсний ногооны орлого бүртгэсэн боловч тулган баталгаажуулалтаар хэрчсэн гурил худалдан авч, анхан шатны баримтыг өөрчилж орлого авсан зөрчил гарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "Худалдан авах ажиллагаа гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт явуулах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг хэлнэ", 29 дүгээр зүйлийн 29.1 "Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерийн үнийг мөрдөх үүрэгтэй", 52 дугаар зүйлийн 52.1 "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хуулийг дагаж мөрдөнө", Санхүүгийн анхан шатны баримтын тухай журмын 20.1.4. "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 1670001019 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 1767472 м² талбай бүхий ЕБС-ийн хашааны газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах

5.3.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг татварын тайланд 123,529.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлд "татвар төлөгч нь орлогоо үнэн зөв тайлагнах үүрэгтэй бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ", 29 дүгээр зүйлийн 29.1.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", 30.5-д "Татвар төлөгч энэ хуулийн 30.4-т заасан

шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах үүрэгтэй бөгөөд татварын алба тайланг хүлээн авна"; Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан бол хариуцлага хүлээлгэнэ" гэсэн зүйлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан "Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам"-ыг баримтлан залруулга хийх

5.3.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан			Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:						Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13				
Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв, иж бүрэн гаргаагүй	53-	603,299.7	4	216,014.7	1	387,285.0	603,299.7	5								
	5	603,299.7	4	216,014.7	1	387,285.0	603,299.7	5								

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй, ажигчдад илүү олгосон цалинг суутгаж аваагүй, Дотуур байр болон бага ангийн хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүнийг нормативаас илүү зарцуулсан	1	7,748.2	1	7,748.2						
Ажигчдад цалинг илүү олгож, суутгаж аваагүй, мөн авлагаар бүртгээгүй	1	2,113.5	1	2,113.5						
Төндөр шалгаруулалтын явцад шалгарсан төндөрийн үнийг мөрдөөгүй бөгөөд худалдан авах ажиллагаанд шалгараагүй нийлүүлэгчээс хүнсний материал худалдан авсан	1	11,967.6			1	11,967.6				

Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын тайланг дуутуу тайлагнасан	1	123,529.2					1	123,529.2	
Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 1670001019 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 1767472 м² талбай бүхий ЕБС-ийн хашааны газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, санхүүгийн тайланд газар эзэмших эрх бүртгээгүй	1						1		
ДҮН	5	145,358.5	2	9,861.7	1	11,967.6	2	123,529.2	

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилгэн дансны тухай хуулийн дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлээгүй	1	2	4	5	6	7	8	9
ДҮН	1	1					1	-